

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 12 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 12 дугаар сард Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 974 болж, 2015 оны мөн үеэс 125 хүнээр, өмнөх сарынхаас 206 хүнээр тус тус өсчээ.

Ажилгүйчүүдийн 45.79 хувь буюу 446 нь эмэгтэйчүүд байна. 2016 оны эхнээс 907 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 813 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 36.41 хувь буюу 296 нь эмэгтэйчүүд байв.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 12 дугаар сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр




Тайлант сард бүртгүүлсэн 380 ажилгүй иргэний 23.16 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 16.05 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 12.63 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 9.74 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 6.84 хувь нь орон тооны цомхтголоор; 6.32 хувь нь шилжин суурьшсан; 1.84 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1.58 хувь нь цэргээс халагдсан; 0.79 хувь нь байгууллага татан

буугдсан; 0.79 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.53 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 19.74 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 12 дугаар сард



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 онд НДШ-ийн орлого 16.09 тэрбум ₮ болж төлөвлөгөө 98.71 хувь болж, төлөвлөгөөг 11 сум 2.65-30.1 хувиар давуулан биелүүлж. Алтанбулаг, Архуст, Аргалант, Батсүмбэр, Баян, Баянхангай, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Заамар, Мөнгөнморьт, Сэргэлэн, Цээл, Эрдэнэ, Зуунмод сумд 0.02-20.98 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 1.14 тэрбум ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 44.2 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо.

Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.6 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 272630 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 35.89 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 25.53%; тэтгэмжийн даатгалын сангийн 69.03%; эрүүл мэндийн даатгалын сангийн 85.29%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 78.43%; ажилгүйдлийн даатгалын сангийн 69.73%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 58689 хүнд олгож, 15.3 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 15.6 хувь 7947 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 9.0 хувь 1.3 сая ₮-өөр тус тус өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 111930 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 49.86 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 19.15 хувийг халамжийн тэтгэвэр; 6.84 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.31 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 3.70 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 5.49 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.70 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Хүн ам

2016 оны жилийн эцэст хүн амын тоо суурин хүнээр тооцоход 92832 болж 2015 оноос 2411 хүнээр өсч, төрөлт 131 хүүхдээр буурлаа.

Нийгмийн зарим үзүүлэлт

Аймгийн хэмжээнд 2016 онд өнчин хүүхэд 980 бүртгэгдсэний 68 (6,9%) нь бүтэн өнчин хүүхэд, 912 (93,1%) нь хагас өнчин хүүхэд байна. 2015 оноос бүтэн өнчин хүүхэд 25 (26.8%)-аар буурч, хагас өнчин хүүхэд 22-оор (2.4%) өслөө. Нийт өнчин хүүхдийн 113(10,4%) нь 0-4 насны, 256 (23,4%) нь 5-9 насны, 332 (30.4%) нь 10-14 насны, 133(12.2%) нь 15 насны, 131(12%) нь 16 насны, 125(11.5%) нь 17 насны хүүхэд байна.

2016 онд байгалийн гамшигт өртсөн хүүхэд 2, амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд 1, садар самуун, хүчирхийлэлд өртсөн хүүхэд 9, зам тээврийн осолд өртсөн хүүхэд 2 гарлаа.

Өрх толгойлсон эх 2016 онд 2104 болж, өмнөх оноос 440 (17,3%)-өөр буурч, өрх толгойлсон эцэг 766 болж өмнөх оноос 42 (5.5%)-оор өсчээ. Өрх толгойлсон эхчүүдийн 1294 (61.5%) нь 3 хүртэлх, 661(31,4%) нь 3-5 хүртэлх, 149(7%) нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлжээ.




1.4 Эрүүл мэнд

2016 онд 16632 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.47 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 онд 1218 хүүхэд мэндэлсэн нь 2015 оноос 56 хүүхдээр буурлаа.

Зураг 1.4


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар



2016 онд 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оноос 8 хүүхдээр өслөө.

Зураг 1.3


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар



2016 онд нийт халдварт өвчнөөр 1207 хүн өвчилсөн нь өмнөх оноос 2.03 хувь буюу 25 хүнээр буурла. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал заг хүйтэн 54,90 хувь, тэмбүү 24,42 хувь, трихомениаз 16,13 хувь, улаан бурхан 4,49 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 133 байгаа бол: Зуунмод 380, Баян-Өнжүүлд 190, Баян 173, Архуст 158, Сүмбэр 123, Угтаал 113, Цээл 112 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар



1.5 Байгаль орчин

Цаг агаарын тойм

Төв аймгийн 2016 оны цаг агаарын байдлыг олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур -13-22 градус хүйтэн, ихэнх нутаг, Дэлгэрхаан, Эрдэнэсант орчмоор сулавтар, томоохон голын хөндий дагуух нутгуудаар 20-22 градус хүйтэн байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь +5,-8 градус, нутгийн хойд хэсгээр хүйтэн, баруун өмнөд хэсгээр сжлавтар, Бүрэн, Дэлгэрхаан орчмоор 4-5 градус хүрч дулаарсан байв.

-шөнийн хугацааны хамгийн бага температур нь 23-36 градус хүйтэн буюу нутгийн баруун өмнөд хэсгээр 23-24 градус, нутгийн зүүн хэсэг, томоохон голын хөндий дагуух нутгууд буюу Алтанбулагт 36 градус хүрч хүйтэрлээ.

- бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0,0-6,7 мм, үүнээс хамгийн их нь Эрдэнэсантад 7,6 мм, бусад нутгаар 0,0-3,9 мм цас орж, одоогийн байдлаар 1-18 см зузаан цастай байна. / өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр /

- Салхи ихэнх хугацаанд баруунаас 3-8 м/с, цас орох үеэр зарим газраар 12-14 м/с, түр зуур 19 м/с хүрч ширүүслээ. Цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдаагүй байна.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

Засгийн Газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын нөхцөл байдлыг үнэлэхэд 12 дугаар сарын 31-ны байдлаар Батсүмбэр, Борнуур, Эрдэнэ, Баянчандмань суманд цагаанаар удархуу байгаа ба, Угтаал, Эрдэнэсант, Зуунмод, Баян, Баян-Өнжүүл суманд удархуу нөхцөл байдал үүсээд байна.

Цаг агаарын байдал хүндэрч, зузаан цасны улмаас мал өвөлжилтийн байдалд бэрхшээл учирч байгаа сумдуудын нутгийн 4 зүгт хийсэн хэмжилтээр цасны дундаж зузаан Жаргалант суманд 25-31 см, Эрдэнэ суманд 20-24 см, Угтаал суманд 11-15 см байв. Цасны нягт дунджаар Угтаал суманд 0.21-0.30 г/см³, Эрдэнэ, Жаргалант суманд 0.17-0.22 г/см³ нягттай зарим газартаа хунгарласан жигд битүү 10 баллын цастай байна.

2017 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар: Энэ сарын агаарын температурын дундаж нь Төв аймгийн нутгийн хойд хэсгээр 24-32 градус, Эрдэнэсант, Дэлгэрхаан орчмоор 11-18 градус, бусад нутгаар 18-24 градус хүйтэн байх ба Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Цээл, Мөнгөнморьт сумдаар дунджаас 0.5-1.5 градусаар хүйтэн, ихэнх нутгаар уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.

Хүйтний эрч сулрах үе: Нэгдүгээр арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст хүйтний эрч суларч Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 24-29 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 17-22 градус, өдөртөө 6-11 градус хүйтэн байна.

Хүйтрэх үе: Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхээр хүйтний эрч чангарч Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 33-38 градус, өдөртөө 23-28 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 27-32 градус, өдөртөө 15-20 градус хүйтэн байна.

Бусад хугацаанд: Голын хөндийгөөр шөнөдөө 29-34 градус, өдөртөө 19-24 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 23-28 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн байна.

Энэ сард нутгийн зүүн хойд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу цас орох

төлөвтэй. Энэ сард нутгийн хойд хэсгээр 2,5-3,4 мм, ихэнх нутгаар 1,5-2,5 мм, нутгийн зүүн өмнөд хэсгээр 0,3-1,5 мм цас ордог бөгөөд Мөнгөнморьт сумын нутгаар уур амьсгалын дунджаас ахиу цас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн хойд хэсгээр цас орох төлөвтэй. Энэ үеэр салхи зарим газраар 12-14 м/с, зарим үед нутгийн өмнөд хэсгээр түр зуур 18-20 м/с хүртэл ширүүсч цасан шуурга шуурах төлөвтэй.

Аюулт үзэгдэл

Аюулт үзэгдэл, осол 2016 оны эхний 6 сард 44 удаа гарсны улмаас 1 хүн амь нас алаж, 1487 толгой мал хорогдлоо. Энэ онд объектын түймэр 23 удаа, шатсан гэр, орон сууц 23 удаа бүртгэгдлээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2016 оны эхний 6 сард 392.5 сая ₮-ийн хохирол учирлаа.

| Аюулт үзэгдэл, осол, 2016 оны эхний 6 сарын байдлаар * | | | |
|--|---------|---------|-----------------------------|
| Үзүүлэлт | 2015 VI | 2016 VI | $\frac{2016-VI}{2015-VI}$ % |
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо | 10 | 44 | 440.0% |
| Аюулт үзэгдэл, ослын улмаас амь нас аалдсан хүний тоо | 1 | 1 | 100.0% |
| Шатсан гэр, орон сууцны тоо | 10 | 23 | 230.0% |
| Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтаны тоо | 52 | 1487 | 2859.6% |
| Объектын түймрийн тоо | 29 | 23 | 79.3% |
| Учирсан хохирлын хэмжээ, сая ₮ | 32.0 | 392.5 | 1226.6% |

Тайлбар: *- Онцгой байдлын газрын мэдээ



1.6 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 онд аймгийн хэмжээнд 812 гэмт хэрэг бүртгэгдэж 817 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 3.5 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.


Гарсан гэмт хэргийн 35.0 хувь нь хулгай, 29.2 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 15.4 хувь нь бусад хэрэг, 15.2 хувь нь замын осол, 4.1 хувь нь танхай дээрэм, 1.1 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Аргалант, Борнуур, Баянжаргалан, Заамар, Эрдэнэ, Жаргалант, Баяндэлгэр, Баянхангай Баянчандмань, Алтанбулаг, Архуст, Баян сумдад 10000 хүнд 535-136 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (129)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 51 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 43 эмэгтэй, 1017 эрэгтэй нийт 1060 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 91 хүнээр буурлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 6.2 хувь нь бүлгээр, 27.4 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 366 хүн гэмтэж, 113 хүн нас барлаа.


Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 онд ажиллагаа хийгдэж байгаа 913 гүйцэтгэх хуудсанд нийт 4.77 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 27 гүйцэтгэх хуудсанд ногдох 894.7 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 886 гүйцэтгэх хуудасны 3.88 тэрбум ₮-өөс 532 хуудасны 1.05 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 60.05 хувь, үнийн дүнгээр 27.08 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 10.66 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 24.43 нэгжээр тус тус буурлаа.

Санхүүгийн хяналт, шалгалт

Аймгийн засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба 2016 онд 110 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 190.7 сая - ийн зөрчил, төлбөр илэрч төлүүлбэл зохих төлбөрийн барагдуулалт 149.5 сая болж 78.41 хувьтай байгаа нь 2015 оны мөн үеэс 78.41 хувиар өслөө.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 онд кассын орлого 464.3 тэрбум ₮, кассын зарлага 466.4 тэрбум ₮ болж, гүйлгээнд 175.3 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 177166, зээлийн багцын дүн 579.0 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 67228 олгосон зээлийн дүн 113.1 тэрбум ₮ боллоо. Иргэдийн хувийн хадгаламжинд 12 сарын 30-ний байдлаар хугацаатай хадгаламж 12.7 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 39.6 тэрбум ₮ байна. Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 12 сарын 30-ны байдлаар 193492 иргэний 8.0 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.08-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна. Төв хөгжил, Түмэн мод, Сонин шийдэл кредит, Интерхэлп, ФишнФанд, Зуун дэлгэрэх банк бус санхүүгийн байгууллагууд 2016 онд 1467 зээлдэгч нарт 3.37 тэрбум ₮-ийн зээл олгож, 3.0 тэрбум ₮-ийн зээлийн өр үлдэгдэл байгаагийн 46.1 сая ₮-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй гарлаа.



II.2 Төсөв, мөнгө

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 10.1 хувь буюу 1.3 тэрбум ₮-өөр

өслөө. Аймгийн төсвийн орлогын 89.08 хувийг татварын, 10.43 хувийг татварын бус, 0.52 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 2.79 нэгжээр өсч, татварын бус орлого 2.06 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.72 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 20.7 тэрбум ₮ болж аймгийнх 11.3 тэрбум ₮ буюу 54.98 хувь, сумынх 2.9 тэрбум ₮ буюу 14.37 хувь, улсынх 6.3 тэрбум ₮ буюу 53.05 хувийг тус бүр бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлого 14.0 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 111.39 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 2.9 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 122.35 хувь биелж, Угтаал, Баянхангай, Сүмбэр, Заамар, Баян, Борнуур, Баянжаргалан, Цээл, Эрдэнэ, Батсүмбэр, Баянцогт, Дэлгэрхаан, Аргалант сумд 48.45-2.04 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 11.3 тэрбум ₮ болж 110.38 хувь биелж Жаргалант, Угтаал, Баянцогт, Баянцагаан, Сүмбэр, Эрдэнэ, Эрдэнэсант, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Борнуур, Мөнгөнморьт сумд төлөвлөгөө 23.54-0.24 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 12 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 65.60%, өмнөх оны мөн үеэс 2.92%-аар, өмнөх сараас 0.26 хувиар тус тус өсөв. ХҮИ-ийн 12 дугаар сарын 0.26 хувийн өсөлтөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.18 нэгж (67.10 хувь), бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.08 нэгж (30.53 хувь)-ээр өссөн нь голлон нөлөөлөв.

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ өмнөх оны мөн үеэс 2.92% өссөний дотор зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 5.29%; тээврийн бүлэг 4.92%; хувцас бөс бараа гутлын бүлэг 4.34%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 3.41%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 2.94%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 0.67%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.36%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 12.94%-аар тус тус өсч, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 0.09%; холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 3.20%-аар тус тус буурав. Боловсролын үйлчилгээний бүлэг; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.

| Бараа, үйлчилгээний бүлэг | 2016 оны I сард | |
|---|-----------------|----------------|
| | пунктээр | хувьд |
| Бүгд | 0.93 | 100.00% |
| 01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 0.09 | 9.97% |
| 02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС | 0.05 | 5.00% |
| 03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ | 0.06 | 6.15% |
| 04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 0.18 | 19.28% |
| 05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА | 0.08 | 8.52% |
| 06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 0.00 | 0.00% |
| 07. ТЭЭВЭР | 0.54 | 57.72% |
| 08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 0.00 | 0.00% |
| 09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ | -0.04 | -3.77% |
| 10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 0.00 | 0.00% |
| 11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 0.00 | 0.00% |
| 12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ | 0.02 | 2.02% |



II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 онд (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 42,78 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оноос 13.0 хувь буюу 4.9 тэрбум ₮-өөр өслөө.


Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны

үнээр, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр,
сая ₮
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

| АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR | 2015 XII | 2016 XII | 2015 I-XII | 2016 I-XII | Дүнд эзлэх % Percentage share to total | | 2016% 2015% |
|---|-------------|-------------|---------------|---------------|--|------------|----------------|
| | | | | | 2015-I-XII | 2016-I-XII | |
| Нийт дүн | 768.59 | 1,795.93 | 37,876.83 | 42,784.86 | 1.0 | 1.0 | 113.0% |
| Ашигт малтмал олборлолт mining and quarrying | 242.54 | 961.69 | 31,214.21 | 36,919.42 | 0.82 | 0.86 | 118.3% |
| Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/ | 322.83 | 621.04 | 5,110.09 | 4,467.50 | 0.13 | 0.10 | 87.4% |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam | 203.22 | 213.20 | 1,552.54 | 1,397.94 | 0.0 | 0.03 | 90.0% |

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, модон эдлэл үйлдвэрлэл, нийтлэх, хэвлэх, дуу бичлэгийн үйл ажиллагаа, ус хариутгал хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 3.3 дахинаас 1.6 хувь буюу 5.7 тэрбумаас- 0.7 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.




Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Эрдэнэ, Батсүмбэр, Баян, Угтаалцайдам сумд 37.93-0.23 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 98.26) хувийг эзлэв.

2016 оны нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 3.27, боловсруулах үйлдвэрлэл 10.44, ашигт малтмал олборлолт 86.29 хувийг тус тус эзлэв.

Орон сууц нийтийн аж ахуй

2016 онд аймгийн хэмжээгээр 23433.75 м² ашигтай талбай бүхий 223 айлын орон сууц ашиглалтанд орж тэдгээрт 117 өрхийн

442 хүн амьдарч байна. Нийт сууцны 97.76 хувь буюу 218 нь төвлөрсөн цахилгаанд холбогдсоны зэрэгцээ 3059 м² талбай бүхий 54 машины граж ашиглалтанд орлоо. Мөн энэ онд 358 гэр шинээр барив. Аймгийн хэмжээгээр 19590 гэр бүртгэгдсэний 18627 өрхийн 56547 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 60.91 хувь нь байна.




II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 онд 5.95 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 онтой харьцуулахад 38.16 хувь буюу 3.67 тэрбум ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 47.49 хувь нь орон сууцны бус барилгад; 37.34 хувь нь орон сууцны барилгад; 14.87 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Үүнийг 2015 онтой харьцуулахад орон сууцны барилгын ажил 23.54 пунктээр, орон сууцны бус барилгын ажил 16.90 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 17.63 пунктээр буурав.

Зураг II.8

Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн эцэст, тэрбум.₮



Хөдөө аж ахуй

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

I.1. Малтай өрх, малчдын тоо. 2016 онд малтай 15.0 мянган өрх, үүний дотор 11.3 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэв. Мөн мал аж ахуйн үйлдвэрлэлд 20.2 мянган малчид ажиллав. Малчдын 44.1 хувь нь буюу 8.9 мянга нь эмэгтэй малчид. Насны бүлгээр авч үзвэл 27.8 хувь нь 16-34 насны, 59.4 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 12.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс юм.

2016 онд малчин өрхийн тоо 2015 онтой харьцуулахад 776-аар, малчдын тоо 1198 -аар тус бүр өслөө. Малчин өрхийн тоо Баянхангай сумд буурч, бусад бүх сумдад өслөө. Бүсээр авч үзвэл нийт малчин өрхийн 39.1 хувь нь Баруун, 22.8 хувь нь Хойд, 19.5 хувь нь Төвийн, 18.4 хувь нь Зүүн бүсэд ногдлоо.

2016 онд нэг малчин өрхөд 388 толгой мал ногдож, 2015 оныхоос 37 толгойгоор буурлаа.

I.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт. Нийт малчин өрхийн 92.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 84.6 хувь нь телевизортой, 48.9 хувь нь авто машинтай, 39.0 хувь нь мотоцикльтой, 7.4 хувь нь трактортой бүртгэгдлээ.

Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд. Иргэдийн хувийн мал

2016 оны эцэст аймгийн дүнгээр 15034 малтай өрх бүртгэгдсэн ба 7.24 хувь буюу 1088 өрх 1000-гаас дээш толгой малтай, 46.22 хувь буюу 6948 өрх 200-гаас дээш толгой мал тоолуулжээ. 2015 оноос 1000-гаас дээш толгой малтай өрх 81 өрхөөр өслөө.

Малын тоо.

2016 оны эцэст аймгийн дүнгээр 4705.8 мянган толгой мал тоологдож 2015 оноос 5.5 хувь 247.2 мянган толгойгоор, малын чанарын үзүүлэлт болох бодод шилжүүлж тооцсноор 1314.9 мянган бод мал тоологдож 2015 оноос 5.3 хувь буюу 66.4 мянган бодоор тус бүр өслөө. Хувийн мал 4661.9 мянган толгойд хүрч аймгийн бүх малын 99.07 хувийг эзлэв. Хээлтэгч мал 2139.7 мянган толгой тоологдож 2015 оноос 7.6 хувь 151.7 мянгаар өслөө. 2016 онд аймгийн дүнгээр малын тэмээ, адуу, үхэр, ямаа 4 төрөл дээр өмнөх оноос өслөө.

Төл бойжилт

2016 онд төллөх насны хээлтэгчийн 83.7 хувь 1663.9 мянган хээлтэгч мал төллөж, 1676.7 мянган төл гарсны 95.5 хувь 1601.9 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 3.1 хувь буюу 52.3 мянгаар; бойжиж буй төл 3.3 хувь 55.0 мянгаар буурч; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 45.5 хувь 520.1 мянгаар, бойжиж буй төл 46.3 хувь 506.7 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 58.4; гүүний 73.5; үнээний 81.1; эм хонины 87.1; эм ямааны 80.6 хувь нь тус бүр төллөв.

Гарсан төлийн 4.5 хувь болох 74782 толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 0.9 хувь буюу 690 төлөөр; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 32.3 хувь буюу 18277 төлөөр өслөө. Гарсан ботгоны 4.1, унаганы 4.8, тугалын 3.6, хурганы 3.3, ишигний 6.5 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянчандмань, Өндөрширээт, Бүрэн, Сүмбэр, Баянцогт сумд гарсан төлийнхөө 16.9-8.1 хувь буюу 9823-1300 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 35.5 хувийг (бүгд 26598 төл) эзлэв.

Том малын зүй бус хорогдол

2016 оны эхний малын 2.7 хувь буюу 121633 том мал зүй бусаар хорогдсон нь 2015 оны мөн үеэс 98.3 хувь буюу 60303 толгойгоор; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 20.8 хувь буюу 20930 толгойгоор тус бүр өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянцогт, Баянчандмань, Угтаал, Баянхангай, Баян-Өнжүүл сумд оны эхний малынхаа 13.11-4.61 хувь буюу 15213-4665 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 60.1 хувь (бүгд 47275) эзлэв.

Оны эхний тэмээний 1.0, адууны 2.4; үхрийн 4.1; хонины 2.2; ямааны 3.3 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 9.3 хувь нь өвчнөөр, 27.7 хувь нь хээлтэгч мал эзлэв.

Тариалалт.

2016 онд аймгийн дүнгээр 83554.0 га үр тариа, 6129.1 га төмс, 947.8 га хүнсний ногоо, 5626.2 га тэжээлийн ургамал, 12133.0 га техникийн ургамал тариалсан нь 2015 оноос үр тариа 1236.5 га, тэжээлийн ургамал 2018.9 га, техникийн ургамал 3237.0 га-аар тус бүр бууоч, төмс 1324.5 га, хүнсний ногоо 142.1 га-гаар тус бүр өслөө.

Тариалсан үр тарианы 10.8%, төмсний 79.1%, хүнсний ногооны 78.9, тэжээлийн ургамлын 48.3%, техникийн ургамлын 28.3 хувь нь тус бүр өрхийн тариалан эрхэлдэг иргэдэд ногдлоо.

Ургац хураалт

2016 онд аймгийн дүнгээр үр тариа 85742.9 тонн; төмс 64696.6 тонн; хүнсний ногоо 8074.4 тонн, тэжээлийн ургамал 12169.9 тонн, техникийн ургамал 5263.5 тонныг тус бүр хураан авсан нь 2015 оноос үр тариа 51.2 мянган тонн, техникийн ургамал 2.3 мянган тонн, хүнсний ногоо 2.5 мянган тонноор тус бүр өсч, төмс 9.0 мянган тонн, тэжээлийн ургамал 3.2 мянган тонноор тус бүр буурлаа.




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого 2016 онд 250.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 87.9 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.28 хувь буюу 52.0 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 108.4 сая ₮ болсон ба нийт орлогын 90.13 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 18.26 хувийг албан бичгийн, 9.87 хувийг зорчигчдын 71.87 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Хүн ам

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 онд төрсөн хүүхэд 2101; нас барсан хүн 592; бусад аймаг, хот руу шилжин явсан 2939; бусад аймаг хотоос шилжин ирсэн 2572 хүн бүртгэгдлээ. Төрсөн хүүхдийн 86.01 нас барсан хүний 100 хувь хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-д оруулжээ.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 онд нийт 11314 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд

баталгаажуулалтыг хийж 55.4 сая ₮-ийн орлого орууллаа.

Нийт орлогын 44.9 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 36.6 хувийг зээлийн барьцаанаас, 8.2 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 4.4 хувийг худалдааны үйлчилгээнээс, 2.8 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 онд нийт 11664 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 449; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 2; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 4691; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 55; бэлэглэлийн гэрээ 238; худалдах, худалдан авах гэрээ 651; өв залгамжлал 85; барьцааны гэрээний бүртгэл 3040; бусад бүртгэл 2453 тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 онд нийт 130 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 85 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 18; шашин 3; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 4; Төсөвт 5; Хоршоо 5; зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай /ЗБН/ 1; бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай /ББН/ 1; хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /ХХН/ 1; орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ 1 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 онд нийт 233 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 70; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 23; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 13; удирдлага өөрчлөгдсөн 40; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 18; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 22; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр

өөрчлөгдсөн 20; татан буугдсан 21; тус бүр бүртгүүлээ. Мөн 66 иргэн, 20 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 онд нийт 296 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 568; үүнээс тохирлын гэрчилгээ 483, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 85; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 3950; үүнээс цулын хэмжүүр 823, жин 701, туухай 112, автомашины жин 10; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 600; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 385, мерник 19, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 12, сүмбэн метр 55, уртын хэмжих хэрэгсэл 15, усны тоолуур 114; нэг фазын тоолуур 2505, гурван фазын тоолуур 22, даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.

Мал эмнэлэг

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2016 онд 7685.1 мянган толгой мал хамрагдсан нь 2015 оны мөн үеэс 148.4 мянган толгойгоор буурлаа. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ халдварт өвчнийх 99.82 хувь, ариутгал халдваргүйтэлийнх 102.97 хувийн гүйцэтгэлтэй биелэгдэж, халдварт өвчнөөр 3927 мал хорогдлоо.



Бизнес регистрийн сан

Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн санд 2016 онд 1919 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 1221 буюу 63.63 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 338 буюу 27.68 хувь нь Зуунмод суманд байна.

Регистрийн санд 2016 онд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулаагүй 698 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 319 буюу 45.70 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 306 буюу 43.84 хувь нь түр зогссон, 45 буюу 6.45 хувь нь бүрэн зогссон, 28 буюу 4.01 хувь нь хаяг тодорхойгүй буюу олдохгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 78.5 хувь нь 1-9 ажиллагчидтай, 8.2 хувь нь 10-19 ажиллагчидтай, 10,9 хувь нь 20-49 ажиллагчидтай, 2.3 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна.